



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/А80

Булган сум

Мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "в", 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал тооллогын ажлыг 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. Мал, тэжээвэр амьтдын тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Аймаг, орон нутгийн эдийн засгийн голлох салбар болох мал тооллогын бэлтгэл ажлыг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, мал тооллогод бүрэн хамруулах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг мал тооллогын ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

4. Мал тооллогыг зохион байгуулахад шаардагдах зардал 6,930,008 төгрөг (зургаан сая есөн зуун гучин мянга найм) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

5. Мал тооллогын ажлыг аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явц, сан бүрдүүлэлт, үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтсийн дарга (М.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

6. Мал тооллогын урьдчилсан дүнг 2023 оны 12 дугаар сарын 28-ны дотор, нэгдсэн дүнг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010932

Аймгийн Засаг даргын 2023 оны
.. дүгээр сарын 23-ны өдрийн А/189 дугаар
захирамжийн хавсралт

2023 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн дарга: Д.Жаргалсайхан (аймгийн Засаг даргын орлогч дарга)
- Ажлын хэсгийн орлогч дарга: М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
- Гишүүд: Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
- Д.Лхагвасүрэн (Татварын хэлтсийн дарга)
- Г.Ганбаяр (Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)
- Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
- Нарийн бичгийн дарга: Ц.Батчимэг (Статистикийн хэлтсийн Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн)